



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 3 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 84

Улаанбаатар
хот

Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн болон яам, Засгийн газрын агентлагийн зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.


2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг дэмжих тухай" Засгийн газрын 2006 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 1 дүгээр тогтоолын 2 дугаар зүйл, "Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2006 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 295 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАЯР

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Б.ДОЛГОР



Засгийн газрын 2009 оны 84 дүгээр
ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАН ЗОХИЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга -Монгол Улсын Ерөнхий сайд
- Орлогч дарга -Эрдэс баялаг, эрчим хүчний сайд
- Гишүүд:
- Сангийн сайд;
 - Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга (зөвшилцсөнөөр);
 - Монгол Улсын Ерөнхий аудитор (зөвшилцсөнөөр);
 - Үндэсний статистикийн хорооны дарга (зөвшилцсөнөөр);
 - Авилгатай тэмцэх газрын дарга (зөвшилцсөнөөр);
 - Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч (тохиролцсоноор);
 - Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга (тохиролцсоноор);
 - “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ерөнхий захирал;
 - “Айвенхоу майнз монголия инк” ХХК-ийн ерөнхий захирал;
 - “Арева Монгол” ХХК-ийн ерөнхий захирал;
 - Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);
 - Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн (тохиролцсоноор);

-“Хил хязгааргүй алхам” төрийн бус
байгууллагын тэргүүн (тохиролцсоноор);

-Нээлттэй нийгэм форумын уул уурхайн
асуудал хариуцсан менежер
(тохиролцсоноор);

-Монголын ажил олгогч эздийн нэгдсэн
холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор).

Нарийн бичгийн
дарга

-Ерөнхий сайдын ахлах зөвлөх

---oOo---